



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/40

Чингис хот

Маш нууц баримт бичиг устгах
Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Батлан хамгаалах сайдын 2019 оны н/19 дүгээр тушаалаар батлагдсан “Монгол Улсын Батлан хамгаалахын Төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 11 дүгээр бүлгийн 11.1, 11.2, 11.3, 11.4, 11.5, 11.6, 11.7, 11.8, 11.9, 11.10 дэх заалтууд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн мн/126 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ашиглагдаж байсан Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар 2004 онд батлуулсан “Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлж, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудыг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”, “Орон нутгийн цэргийг байгуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөө” болон шинээр батлагдсан төлөвлөгөөний ноорог хуудас, төслийг дор дурьдсан комиссын бүрэлдэхүүн 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдөр устгалд оруулсугай.

2. Устгалын комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Н.Хүрэлээ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга Хурандаа
Гишүүд:	Б.Дарханбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Л.Цэнддорж	Аймгийн Засаг даргын Тамгын Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер Хошууч
	С.Галбадрах	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалт хариуцсан офицер Хошууч
	Ц.Мягмар-Ариунаа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч

2.

3.Цэргийн штабт ашиглагдаж байгаад устгалд оруулсан баримт бичгийн актын 1 хувийг Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газарт хүргүүлж 2021 оны 6 дугаар сарын 30-нд илтгэхийг устгалын комисс (Н.Хүрэлээ)-т даалгасугай.

ДАРГА  Ж.ГАНБААТАР